

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын 2023 оны 09 дугаар сарын 13-ны өдрийн 1/24 дугаар тушаалын 69 дүгээр хавсралт



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар

Нэгжийн нэр:

Үйлдвэрлэл, үйлчилгээний алба

Албан тушаалын нэр:

Зөөгч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Туслах ТҮ-1

Ажлын цаг:

Ажлын 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж - 9, 1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Шаардлагатай үед амралт, баяр ёслолын өдрүүдэд ажиллах

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЧИГ ҮҮРЭГ

#### Албан тушаалын зорилго:

Нийслэлийн Төр захиргааны болон Засаг захиргааны байруудад үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэдэд болон хүндэтгэлийн хүлээн авалтад үйлчилгээ авч байгаа зочидод үйлчилгээний чанар, стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлэх.

#### Албан тушаалын зорилт:



1.Зөөгч нь байгууллагынхаа зоогийн үйлчилгээний онцлог нэг бүрийг мэддэг,

ямар бүтээгдэхүүн үйлчилгээг хослуулан хэрэглэвэл зохих, эс зохицох тухай дэлгэрэнгүй мэдээллийг үйлчлүүлэгчдэд өгөн зөв сонголт хийхэд нь туслах.

2.Зоог барьж буй зочид үйлчлүүлэгчдэд соёлтой шуурхай үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх.

3.Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хүнсний тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоол шийдвэр, журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага стандарт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг хэрэгжүүлж ажиллах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах-Т Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Зоогийн газрын ахлах менежер, зохион байгуулагчийн шууд удирдлаган дор өгсөн үүрэг даалгаварыг түргэн шуурхай хийж гүйцэтгэх</p> <p>1.2.Хүндэтгэлийн хүлээн авалтын болон өдөр тутмын хоолны ширээг стандартын дагуу засах</p> <p>1.3.Зоогийн газрын хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, ариг гамтай хэрэглэх.</p> <p>1.4.Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчдэд тухайн өдрийн хоолны нэр төрлийг танилцуулах.</p>	Зоогийн газрын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Зааланд зоог барьж буй зочид үйлчлүүлэгчдэд соёлтой хөнгөн шуурхай, үйлчилгээний стандартын дагуу үйлчилгээг үзүүлэх.</p> <p>2.2.Бохир хэрэгслийг түргэн шуурхай хураах, ширээ дээрх /сальфетка, хоол амтлагч/ хэрэгслийн бүрэн дүүрэн эсэхэд хяналт тавих, хангалт хийх.</p>	Үйлчлүүлэгчдээс санал, гомдол гаргалгүй ажилласан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1.Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллах</p> <p>3.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөж ажиллах.</p> <p>3.3.Удирдлагаас өгсөн үүрэг</p>	Хууль, дүрэм журмыг хэрэгжүүлж, зөрчилгүй ажилласан байна.	Г

	даалгаврыг хэрэгжүүлэх.		
<b>III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</b>			
<b>Боловсрол</b>	Мэргэшлийн сургалтад хамрагдсан		
<b>Мэргэжил</b>	Зөөгч		
<b>Мэргэшил</b>	Зөөгчийн мэргэшлийн сургалтад хамрагдсан байх		
<b>Туршлага</b>	Үйлчилгээний байгууллагад 1-ээс доошгүй жил ажилласан байх.		
<b>Ур чадвар</b>	Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага ханган ажиллах, үйлчлүүлэгчийн захиалга, хүсэлтийг зөв боловсон хүлээж авах, харилцааны болон үйлчилгээний соёл эзэмшсэн, хүнтэй харилцах ур чадвартай байх, үнэр амтны мэдрэмж сайтай гарын эв дүйтэй, хурдан шуурхай хөдөлгөөнтэй, биеийн хөдөлгөөний зохицолдолгоо тэнцвэр сайн байх.		
<b>IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ</b>			
<b>Албан тушаалыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр:</b> Үйлдвэрлэл, үйлчилгээний албаны дарга Үйлчилгээний ерөнхий менежер Зоогийн газрын ахлах менежер Зоогийн газрын зохион байгуулагч Тооцооны нягтлан бодогч/Зоогийн газрын/ Ахлах тогооч			
<b>Албан тушаалын шууд харъяалан удирдах албан тушаал:</b>			
<b>Албан тушаалын байгууллага дотор харилцах субъект:</b> Үйлдвэрлэл, үйлчилгээний албаны дарга Үйлчилгээний ерөнхий менежер Зоогийн газрын ахлах менежер Байр хариуцсан менежер Ажилтан, албан хаагчид		<b>Бусад харилцах субъект:</b> НИТХ, НЗДТГ, Захирагчийн ажлын алба, НЗД-ын хэрэгжүүлэгч агентлагууд, бусад төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд	
<b>V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</b>			
<b>Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсгийн ахлагч:</b>		<b>Ажлын байрны тодорхойлолтыг баталсан:</b>	
Албан тушаалын нэр: ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР		Албан тушаалын нэр: НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ	
 ..... Б.ЗОЛБАЯР (гарын үсэг) (овог, нэр)		 ..... Л.ДЭЛГЭР (гарын үсэг, тамга) (овог, нэр)	
2023 оны 09 дугаар сарын 13-ны өдөр		2023 оны 09 дугаар сарын 13-ны өдөр	